

ҮР ТАРИАНЫ САЛБАР ДАХЬ ТЕХНИКИЙН ХАНГАМЖИЙН АСУУДАЛД

Ж. Сувдаа

ХААИС, Эдийн засаг бизнесийн сургууль

suvd9jal@yahoo.com

ХУРААНГУЙ

Цаг үеийн нөхцөл байдлыг харгалзан техникийн хэрэгцээ, хангамжийн түвшинг эргэн тооцох шаардлага байгаа юм. Техник технологийн дэвшил өөрчилтийг тусгах зорилгоор “ТЭ-150” трактор, “Нива- Эффект”, “Вектор 410” комбайныг жиших нэгжээр сонгон авч нийт зүтгэх хүчний хэрэгцээг биет болон жиших нэгжээр илэрхийлэнтехникийн хангамжийн түвшинг тодорхойллоо.

Энд хэрэглэгдсэн судалгааны аргыг Монгол улсын хөдөө аж ахуйн байгууллагуудын машин –тракторын паркийн өнөөгийн байдлыг үнэлэх, өөрчлөгдөж байгаа тариалангийн талбайн хэмжээ болон өсөн нэмэгдэж байгаа паркийн хүчин чадалтай уялдуулан паркийн шинэчлэлийг төлөвлөх, хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад ашиглах боломжтой юм.

ТҮЛХҮҮР ҮГС: Норматив, жиших нэгж, шилжүүлэх коэффициент, техникийн хэрэгцээ, паркийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт

ОРШИЛ

Албан бус мэдээгээр 1990 оноос 2011 онуудын хооронд тракторын тоо бараг 3.2 дахин, комбайны тоо хоёр дахин буурсан байна.

Хэдийгээр зүтгэх хүчний бодит тоо нь социализмын үеийнхээс цөөрсөн ч гэсэн олон үйлдэл хийх боломж, угсрааны авцын өргөн, хүчин чадалзэргээрээилүү болсон нь хөдөө аж ахуйн ажлын хэмжээг оновчтой агротехникийн хугацаанд цөөн тооны механикжуулагчаар гүйцэтгүүлэх боломж бүрдүүлэх талтай[7].

Тракторын хангамж

2011 оны байдлаар манай улсад нэг тракторт 686 га эргэлтийн талбай^[2] ногдож байгаа нь хангамжийн асуудал хүнд байгааг харуулж байна.

Шаардагдах тракторын тоог2009 оны“Нормативы на средства механизации для сельского хозяйства Западной Сибирского экономического района^[3]”, 1976 оны “Методика использования условных коэффициентов перевода тракторов, зерноуборочных и комбайнов в эталонные единицы при определении их потребности^[4]” удирдамжууд дахь нормативыг үндэслэн тооцов.

1000 га-д шаардагдах нормативын хувьд2009 оных өндөр байна. Энэ ньгазар тариалангийн салбарын эрчимжилт, өссөн нэмэгдсэн эрэлт хэрэгцээтэй холбоотой юм^{[3][4]}.

Улс орноор нь авч үзвэл манайд байгаа тракторуудын 80% нь ОХУ-ых байгаа бөгөөд цаашид ч гэсэн манайдоросын техникийг түлхүү ашиглах хандлагатай байгаа[6]. Иймд тракторын хангамжийн түвшинг биет нэгжээс гаднажиших нэгжээроросын ТЭ-150 тракторыг сонгон тооцов.

Техникийн дэвшлийг тусгасан засварлагдсан нормативын үндсэн дээр шаардагдах тракторын тоог тодорхойллоо.

ХЭРЭГЛЭДЭХҮҮН, АРГА ЗҮЙ

Судалгааны ажлын зорилго нь үр тарианы салбар дахь техникийн хэрэгцээ, хангамжийн түвшинг тодорхойлж үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

Шинжлэх ухааны дэвшлийг тусгасан засварлагдсан техникийн нормативаар шаардагдах техникийн тоогбиет болон жиших нэгжээр тооцож гаргав. Эцэст нь техникийн бодит тоог хэрэгцээтэй нь харьцуулах замаар хангамжийн түвшинг тодорхойллоо.

Хүснэгт 1

Хэрэгцээг тракторын тоо

Татах хүч, т	Шаардагдах тракторын тоо			
	биет нэгжээр		жиших нэгжээр	
	2009 оны нормативаар	1976 оны нормативаар	2009 оны нормативаар	1976 оны нормативаар
8	42.96		50.12	
6	257.76		315.04	
5	1253	572.8	1510.76	716
4	730.32		880.68	
3	1668.28	1646.8	1997.64	2004.8
2	358		436.76	
1.4	393.8	1861.6	479.72	2219.6
0.9	50.12		57.28	
0.6	229.12	214.8	272.08	286.4
Дүн	5012	4296	6000.08	5226.8

Хүснэгт 1 дэх техникийн тоо, 2011 оны статистикийн мэдээг ашиглан тракторын хангамжийн түвшинг тодорхойлж Хүснэгт 2-рт харуулав.

Хүснэгт 2

Тракторын хангамжийн түвшин

Тракторын биет тоо, шир	Шилжүүлэх дундаж коэффициент, Ку	Тракторын тоо жиших нэгжээр, шир	Нийт эргэлтийн талбайд шаардагдах жиших тракторын технологийн хэрэгцээ, шир	Жиших нэгжээр илэрхийлсэн биет тракторын болон технологийн хэрэгцээг тракторын зөрүү (жиш.нэгжээр), +/(-)	Биет нэгжээр илэрхийлсэн тракторын болон технологийн хэрэгцээг тракторын зөрүү. +/(-)	Тракторын хангамжийн түвшин, %
Биет нэгжээр						
2009 оны нормативаар						
758	1.2	909.6	5012	-4104.4	-3418.7	18.15
1976 оны нормативаар						
758	1.2	909.6	4296	-4800	-2822	21.18
Жиших нэгжээр						
2009 оны нормативаар						
758	1.2	909.6	6000.08	-5090.48	-4242.1	15.16
1976 оны нормативаар						
758	1.2	909.6	5226.8	-4317.2	-4355.7	17.4

Хүснэгт 2-н дагууниг тракторын хангамжийн түвшин биет нэгжээр 18.15-21.18%, жиших нэгжээр 15.16-17.4% байна. Ингэхдээ тракторын хангамжийн

түвшин нь биет нэгжийхээс ойролцоогоор 16-17% - иар доогуур гарав.

Үр тарианы комбайны хангамж

Улсын хэмжээнд үр тариаг цаг хугацаанд нь чанартай, зардал багатайгаар хураахын тулд зохих парк бүрдүүлэх шаардлагатай байдаг. Гэтэл 2012 оны байдлаар нэг комбайнд дунджаар 265 га талбай ногдож байна[2].

Мэргэжилтнүүдийн зөвлөж байгаагаар паркад өнгөрүүлэх чадвараас нь хамааруулан 3 кг/с –тай комбайн– 10%, 5-6 кг/с-тай комбайн–45%, 7-8 ба 8-9 кг/с -тай комбайн– тус бүр 20%, 11–12 кг/с -тай комбайн – 5% байвал зохилтой гэж үздэг байсан юм[5]. Гэвч сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн эрчимжилттэй холбоотой парк дахь хүчин чадлын харьцаа өөрчлөгдөж байна.

Жишээ нь, өнгөрүүлэх чадвар нь 3 кг/с –тай комбайнуудын эзлэх хувь буурч, 9-10 кг/с –тай комбайных өссөн байна[3]. Манай улсад үр тариа хураадаг 1000 орчим нэгж техник байдаг ба түүний 60 хувь нь Ростовын үйлдвэрт үйлдвэрлэжээ. Хөдөө аж ахуйн техник худалдаж авах улсын тендерт 2013 оноос өөрчлөлт орж газар тариалан эрхлэгчид тариа хураах техникээ өөрсдөө сонгож, “Вектор-420” комбайн болон “Ростовсельмаш” компанийн бусад техникийг Монгол Улсын хөдөө аж ахуйд нэвтрүүлэх бодлогыг яамнаас баримталахаар мэдэгдсэн байна^[6]. Иймд дээрхтэй уялдуулан үр тарианы комбайны хэрэгцээг “Нива-Эффект” болон “Вектор 410” жиших комбайныг үндэслэн тодорхойлж Хүснэгт 3 –т харуулав.

Хүснэгт 3

Үр тарианы комбайны хэрэгцээт тоо, ширхэг

	Комбайныхэрэгцээ, ширхэг					Нийт
	Ангилал, кг/с					
	5 – 6	6 – 7	7 – 8	9 – 10	11 – 12	
Биет нэгжээр	651.5	690.9	676.6	1002.4	46.5	3068.0
"НиваЭффект" - жишихнэгжээр	651.5	816.2	934.3	1743.4	100.2	4245.8
"Вектор 410"- жишихнэгжээр	469.1	594.1	676.2	1242.9	74.9	3057.8

Хэрэгцээт комбайны тоог “Вектор 410”-р тооцсон үед “Нива Эффект”-ээр тооцсоноос ойролцоогоор 28%–аар бага байна. Гэхдээ биет нэгжээр тооцсонтой харьцуулахад тоо нь ойролцоо байгаа боловч түүний

бүтцэд өндөр хүчин чадалтай комбайн илүү хувь эзэлж байна. Хүснэгт 4-т 2011 оныкомбайны хангамжийн түвшингстатистикийн мэдээн дээр үндэслэн тодорхойлов.

Хүснэгт 4

Үр тарианы комбайны хангамжийн түвшин

Комбайны тоо биет нэгжээр, шир	Шилжүүлэх дундаж коэффициент, Ку	Комбайны тоо жиших нэгжээр, шир	Нийт тариалсан талбайд шаардагдах жиших комбайны технологийн хэрэгцээ, шир.	Жиших нэгжээр илэрхийлсэн биет комбайн болонг ехнологийн хэрэгцээт комбайны зөрүү (жиш.нэгжээр), +/(-)	Биет нэгжээр илэрхийлсэн комбайн болон технологийн хэрэгцээт комбайны зөрүү, (+/(-)	комбайны хангамжийн түвшин, %
Биет нэгжээр						
1104	1.2	1324.8	3068.06	-1743.26	-1452.72	43.18
Жиших нэгж -"НиваЭффект" комбайнаар						
1104	1.2	1324.8	4245.88	-2921.08	-2434.23	31.20
Жиших нэгж -"Вектор 410" комбайнаар						
1104	1.2	1324.8	3057.86	-1733.06	-1444.22	43.32

Хүснэгт 4-н дагуу үр тарианы комбайны хангамжийн түвшин биет нэгжээр-43.18%, "НиваЭффект"

комбайнаар-31.23%,"Вектор 410"комбайнаар-43.32% гарав.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Сүүлийн жилүүдэд үр тарианы салбарт техникийн шинэчлэл багагүй хийгдсэн боловч зүтгэх хүчний хангамжийн асуудал хурцаар тавигдсан хэвээр байна. Статистикийн албан ёсны мэдээг ашиглан судалгаа хийхэд 2011 оны байдлаар тракторын хангамжийн түвшин биет нэгжээр 18.15-21.18%, жиших нэгжээр 15.16-17.4% байна. Энд жиших нэгжээр тооцсон тракторын хангамжийн түвшин нь биет нэгжээр тооцоноос ойролцоогоор 16-17% -иар доогуур байгаа юм.

Үр тарианы комбайн дээр хангамжийн түвшин нь 2011 оны байдлаар биет нэгжээр - 43.18%, жиших "НиваЭффект" ба "Вектор 410"комбайнаар-31.23, 43.32% байна.

Хэдийгээр тус ажил нь илүү онолын талын судалгааболсон ч гэсэн энд хэрэглэгдсэн судалгааны аргыг цаашид Монгол улсын хөдөө аж ахуйн байгууллагуудын машин –тракторын паркийн өнөөгийн байдлыг үнэлэх, өөрчлөгдөж байгаа тариалангийн талбайн хэмжээ болон өсөн нэмэгдэж байгаа техникийн хүчин чадалтай холбогдуулан

машин тракторын паркийн шинэчлэлийг төлөвлөх, хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад ашиглах боломжтой юм.

НОМ ЗҮЙ

1. “Атрын гурав дахь аян” үндэсний хөтөлбөрийн төгсгөлийн шатны хяналт- шинжилгээ, үнэлгээний тайлан.УБ: 2011
2. Монгол улсын статистикийн хороо “Монгол улсын статистикийн эмхтгэл”.УБ: 2003- 2011.
3. РАСХРФ, МПТРФ. “Методика использования условных коэффициентов перевода тракторов, зерноуборочных и кормоуборочных комбайнов в эталонные единицы при определении нормативов их потребности”.М.: 2009
4. “Нормативы на средства механизации для сельского хозяйства Западной Сибирского экономического района”. М:1976 -5х
5. “Аграрное обозрение”.М: 2010№2(18) -18х
6. “Монголын хөдөө” сонин.УБ:2013№29
7. БатдэлгэрГ. “Трактор засварын газар Монголд хэрэгтэй байна”. УБ:2012 №264 (4279)

ABSTRACT

In conformity with nowadays requirements there is need to re-estimate the technics need incrop productionand their availability rates.

The required technics number have been estimated in physical and etalon unitsby using technical normative requirements per 1000 hectare, converting coefficients and optimal power ratio within machinery park. TE-150 tractor, Nivea-Effect and Vector-410 combines were chosen as etalon units.

Current research method can be used for the analyzing current situation in machinery –technical parks ofcrop sector, for the planning of machinery- technical park modernization and implementation of investment projects in connection with changing field sizes and increased technical capability.